



ХЭНТИЙ АЙМГИЙН  
ДАДАЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2025 оны 04 сарын 14 өдөр

Дугаар 01

Баян-Овоо

Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласан  
газарт нөхөн сэргээлт хийх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг, 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэг, 35 дугаар зүйлийн 35.1.18 дахь заалт, Байгаль орчны хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх заалт, Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын 2022 оны 8 дугаар сарын 29-ны өдрийн А/328 дугаар тушаалаар батлагдсан “Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлосон газарт нөхөн сэргээлт хийх аргачлал”-ын 5, 6 дахь хэсгийг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тавдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр Олон улсын төсөл хөтөлбөр, улсын төсвийн хөрөнгө оруулалт, аймаг, сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө, иргэн, аж ахуйн нэгжүүдийн хийж буй бүтээн байгуулалтын ажилд шаардагдах нөөцийг техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх замаар талбайгаас гарсан түгээмэл тархацтай ашигт малтмалыг ашиглахыг зөвшөөрсүгэй.

2. Эвдэрсэн газрыг нөхөн сэргээх зардлаас биологийн болон техникийн нөхөн сэргээлт хийх ажлын техник, тоног төхөөрөмжийн шатахууны зардалд 3,000,000 /Гурван сая/ төгрөг олгож, нөхөн сэргээлтийг чанартай хийлгэж хүлээж авахыг Байгаль орчны хяналтын улсын байцаагч (Д.Батзориг)-т даалгасугай.

3. Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлосон газарт аргачлалын дагуу техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг хийлгэж, ажлын хэсэг байгуулан хүлээн авч ажиллахыг сумын Засаг дарга (Ш.Мөнххуяг)-т үүрэг болгосугай.



010000064